

ЮАНЬ ГҮРНИЙ ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ГАР УРЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭЭ УГАЛЗНЫ ДҮРСЭД ХИЙСЭН СУДАЛГАА

Б.Төгсөө, ӨМБИС

Abstract

After the establishment of the Yuan Dynasty, the government has taken in charge of the business issues and handcraft industry which make the flourish in the variety of materials and more effective at the same time. As the economy flourishes the nobilities even the plain folks, the exquisite handcraft ornaments become their favorites. In those gold, silver, metal articles for the daily use, such as porcelain vase, carpet, knitted fabric handcraft, art pattern became a branch of national craft technology and have a far-reaching influence at that time. The variety of handcraft industry has flourish the kinds of handcraft, even the technology and design of manufacture. The main reason of the culture even art development at that time is the specific culture atmosphere and the communications. Under these condition, we are going to discuss the development of art pattern at that time. From the view point of research on Mongolian art patterns, the conception methods make the variety of conception become possible.

Түлхүүр үг

Юань гүрэн- аж байдал, гар урлал, хээ угалз, дүрсийн судалгаа

Удиртгал

Юань гүрний үеийн аж байдлын тойм

XII зууны сүүлчээр умардын тал нутагт нүүдэллэн амьдарч байсан Монгол овог аймгууд улмаас улам хүчирхэгжин мандаж, Хятадын нутаг дэвсгэрт анхны цөөн тоот үндэстэн ноёрхсон их гүрнийг байгуулсан юм. “1271 оны 11 сард Хубилай И Жин Чянь Юаний санааг үндэслэн улсын нэрээ Их Юань хэмээн тунхагласан юм” (Балжинням нар. 2005.х.137) Энэхүү Их Юань гүрэн нь Хятадын түүхэнд аж ахуй, улс төр, шашин шүтлэг, ялангуяа соёл урлагийн олон талбарт маш их түүхэн нөлөө үзүүлсэн. Дундад болон Баруун Азиас Юань гүрнийг чиглэсэн их урсгал хүчээ авч, нийгэм, улс төр, шашны зүтгэлтнүүд, худалдаачид, гар урчуудын цуваа тасралтгүй үргэлжилж, түүнийг дагасан бараа таваар, ховор сонин эд зүйлс зах зээлийг бүрхэн, ихэс дээдсээс эхлээд энгийн ардын хэрэглээнд хүртэл нэвтэрчээ. Монголын уламжлалт нүүдэлчин соёл, Хятадын суурьшмал соёл, Дундад болон Баруун Ази, Европ соёлын харилцан нөлөөлөл, нийгэм-улс төрийн хөдөлгөөнт орчинд Юань гүрний өвөрмөц онцлог бүхий соёл урлагийн өнгө төрх ийнхүү бүрэлдэж эхэлжээ. Юань улс байгуулагдсаны дараа цэрэг дайны байлдах бодлого, улс нийгмийн хэрэгцээ шаардлагын улмаас Юань улсын төрөөс үйлдвэрлэлийг идэвхтэй дэмжиж байв. Хятадын өмнөд нутгаас их хэмжээний гар урчуудыг элсүүлэн цуглуулж, урчуудын өрхөд хамааруулан үйлдвэрлэл эрхлүүлэх болов. Алт мөнгө, төмөр эдлэл хэрэгсэл, шаазан ваар, хивс,

нэхмэл зэрэг гар урлалын үйлдвэрлэл худалдааг өргөнөөр хөгжүүлэн дэмжихийн тулд улсын дотоод дахь эл зүйлийн шилдэг гар урчуудыг сонгон төвлөрүүлээд, гар урлалын төрөлжсөн үйлдвэрийг хөгжүүлж байлаа. “1275 онд арав гаруй түмэн гар урчуудыг элсүүлэн үйлдвэрлэл эрхлүүлж байв. Улсын хэмжээнд 310 гаруй том жижиг гар үйлдвэрлэлийн товчоо байснаас 70 гаруй нь том хэмжээний үйлдвэрлэлийн газар байсан” (Ганболд Ж.нар. 2006. х.73) тухай түүхийн судалгаагаар тодруулжээ. “Алт, мөнгө, сувд, хаш, мөнгөн ус, төмөр, тугалга, цагаан тугалга, шунх, хужир, шүү зэрэг хорь гаруй төрлийн ашигт малтмалыг нээн ашиглаж, заримыг нь улсаас шууд эрхэлж, заримыг нь хувь хүнд өгч эрхлүүлээд улсаас татвар хураадаг байв” (Ганболд Ж.нар. 2006. х.73) Дотоод дахь гар урлалын хөгжлийг улмаар ахиулахын тулд Перс, Иран зэрэг гар урлал өндөр хөгжсөн газар нутгуудтай эд материал, гар урлалын техник технологийн солилцоог мөн өргөнөөр явуулж, туршлага солилцож, гар урлалын төрөл зүйл, арга технологи, хийц маягийг өндөр төвшинд хөгжүүлж чаджээ. Хятадын уламжлалт гар урлалын төрлүүд шаазан, нэхмэл, алт мөнгөн урлал, арьс ширэн эдлэлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн чимэглэл хээ угалзыг хөгжүүлэн баяжуулснаар барахгүй, Дундад болон Баруун Ази, Европын гар урлал, чимэглэлийн урлагийн нөлөөг тусган авч, хээ чимэглэлийн урлагийн

* ✉ 1715277115@qq.com

шинэ хэв маяг, өнгө төрхийг болгосон нь тухайн үеийн гар урлалын онцлог бөгөөд давуу тал болжээ. Үүнд:

1. Бөс нэхмэлийн хээ угалз

Юань улсын үед нэхмэлийн эх бүтээгдэхүүн болон төрөл зүйл олон янз чанартай болон хөгжжээ. Онцгойлон Хятадын торгон нэхмэлийн суурин дээр Монгол уламжлалт ноосон нэхмэлийн арга мэргэжил, Дундад болон Баруун Азийн бөс нэхмэлийн бүтээгдэхүүн үйлдвэрийн ур мэргэжил хослуулсан нь өндөр түвшинд хүрсэн байна. Үүнээс Монголчуудын нүүдэл амьдралд хамгийн өргөнөөр хэрэглэж үйлдвэрлэж байсан бөсний төрөл бол ноосон нэхмэл болон хөвөн нэхмэл болно. Юань гүрний хүн амын дийлэнх хувийг Хятадууд эзэлж байсны дээр, ер ардын дунд суурьшмал амьдралын хэвшил нэлээд түгээмэлжсэнийг дагаад хөвөн нэхмэл бүтээгдэхүүн ихээр шаардагдах болсон байна. Юань улсын эдийн засгийг хөгжүүлэх үндэс нь газар тариаланг хөгжүүлэх явдал байв. Хубилай хаан “Улс ану ард иргэдээр үндэс болгомой. Ард иргэд ину идэж өмсөхөөр үндэс болгомой. Идэж өмсөх нь тариалан ялмаар үндэс болгомой” (Юань улсын судар. 93-р боть) хэмээн үзэж, ийм утгатай тунхаг бичгийг орон даяар тархааж байжээ. (Ганболд Ж нар, 2006.х.57) Тухайн үед хөвөн ургамлыг Шан Ши, Жиян Су, Хө Жиян, Фу Жиян, Гуан Дун зэрэг оронд төрийн хамааралттайгаар маш ихээр тарьж ургуулан, үйлдвэр, борлуулалтын төвүүдийг байгуулсан (Хуй Гү. 2008. х.225) байдаг. Ингэж Хятадын уламжлалт мяндас олсны нэхмэлийн эдийг тарьж боловсруулах тариалан, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлснээр, эгэл ардын хувцас өмсгөлийн гол материалыг дотооддоо хангаж чадсан байна. Хөвөн нэхмэл бүтээгдэхүүний хангалт сайжирч, ардын дунд өргөнөөр тархагдсаны улмаас төрөл зүйл, арга хийц, өнгө үзэмж хээ угалзын хувьд олон төрөл хөгжиж, ур хийцийн хувьд ч улам бүр боловсорчээ. Хөвөн нэхмэлийн хээ угалзад цэцэг навч, амьтан шувуу, өвс ургамал, геометрийн дүрс ба өлзий бэлгэдлийн хээ угалз голлож, хийц маягийн хувьд хэвлэх, дарамлах, хатгах, ширдэх, будах, товойлгох зэрэг олон арга мэргэжлийг уралдуулах болсон байна. Үүний дотроос хөх, цагаан өнгөөр цэцэг ургамлын хээг тодруулж, будах аргаар хээлж үйлдвэрлэсэн хөвөн нэхмэл бүтээгдэхүүн Юань гүрний эгэл ардын дунд ихэд дэлгэрээд байжээ. (Наранхүү., Ян Жин. 2006.х.67) Хээ угалзыг хатгаж, дарамласан бус, харин хэвлэж гаргасан учир үнэ өртгийн хувьд дөхөм байсны учир ийнхүү эгэл ардын дунд дэлгэрсэн бололтой.

Нэхмэлийн гар үйлдвэр нэлээд өндөр төвшинд хөгжсөн бөгөөд түүний дотор төрөөс эрхэлсэн үйлдвэрлэлийн газар нэлээд чухал байр суурийг эзэлж байв. Улсын хэмжээнд торго, дурдан, хоргой магнаг нэхэж будах хэлтэс 16, нэхэж будах товчоо 33, байсны (Ганболд Ж нар.2006. х.75) олонх нь умард нутгаар тархсан байж. Дайду хот, Дээд нийслэл зэрэг том суурин газруудад улсын олон хувийн гурван түм орчим нэхмэлийн урлан, үйлдвэрлэлийн газар байсны (Хуй Гү. 2008.х.254) дээр мөн гадаад улс орноос их хэмжээний бөс материал татан оруулж байжээ. Ердийн эсгий ширдэг нь хөх, цагаан, хар, улаан, шар, хүрэн зэрэг цулгүй өнгийн байж, хайчилмал, наамлын аргаар уран сэтгэхүй, нарийлаг хийцтэй хээ угалз тодруулан бүтээж байжээ. Хээ угалзын хэлбэр дүрсийг бор зургийн дагуу хайчилж, өөр өнгийн эсгий ноосонд хатгаж оёх, шаглах, ноосруулж барьцалдуулах зэрэг аргаар майхан буюу хивс болгон чимэглэн хэрэглэж байжээ. Ноосоор утас ээрч, элдэв өнгийн хээ угалзыг зохицуулан сүлжилдүүлэн нэхсэн бараа бүтээгдэхүүн нь Монголчуудын өдөр тутмын хэрэглээний гол чимэглэл болж байсан юм. Түүнийгээ ороолдуулан солбицуулах, хайчлан наах, шаглан сийлэх аргаар уул ус, асар тагт, цэцэг, шувуу, хүн амьтан болон геометрийн дүрстэй хээ угалз урлан бүтээж, тав, долоо, есөн өнгө (Амарбат. 2008. х.16) гэх мэтээр өнгийг хоршуулна. Хээ угалзын ур хийц нарийн, гүйцэтгэл чамбай байсан нь ноосон нэхмэлийн урлал Юань гүрний үед нэлээд дэлгэр хөгжиж, зохих өндөр төвшинд хүрснийг илтгэнэ.

Зураг 1

Цэцгэн хээт бөс. Юань улс



Юань гүрний үед ихэд дэлгэрсэн өөр нэгэн зүйлийн бөс материал бол торго юм. Элдэв зүйлийн найр хурим, ордны дэг ёс нарийн ялгалтай тогтож журамлагдсаны учир үүнийг дагалдаад торгоны хэрэглээ мөн өндөр төвшинд хүрчээ. Тухайн үед Иран, Персээс ирсэн эрээн мяраан торго дурдангын худалдаа наймаа, тансаг зэрэглэлийн торгоны үйлдвэрлэл урьд өмнө

байгаагүйгээр өргөжин тэлж, дээд зиндааныхны эрх мэдэл, бэл бэнчингийн нэгэн илрэл болжээ. Олон зүйлийн торгоны дундаас наашиш хэмээх торго хамгийн үнэтэй нь байж, язгууртан ноёдын дунд ихэд дэлгэрчээ. “Наашиш бол Монголын хуучин ноёдын хэрэглэдэг алтан утсан нэхмэл бүхий нэгэн зүйл торго болно” (Наранхүү, Ян Жин. 2006.х.66)

Иймэрхүү алтан саагаар утас ороож үйлдээд, түүнээ нэхмэл болгон зохион эсгэсэн хувцсыг “Зүсэм” дээл гэдэг. Юань улсын нийгэм соёлын байдал бол нэн олон талтай буюу олон үндэстэн угсаатан зэрэгцэн оршсон олон соёлын бөөгнөрөл, эд материалын элбэг хангалуун байдал нь соёл урлагийн өргөжин хөгжих нэгэн тааламжтай орчин байжээ. Соёлын энэ таатай уур амьсгал дунд урчууд дархчуулын ухааны ур хурцасч, гарын ур тэгширч, уламжлал шинэчлэлийг сүлэлдүүлснээр хэлбэр дүрс, хэв маяг, өнгө дүрслэл, бэлгэ билэг хосолсон хээ угалз-чимэглэлийн урлаг цулгаран бүтээгджээ. Үүнд мандарваа, удвал, лянхуа, тоор, анар, гүйлс, навч ороомол зэрэг цэцэг ургамлын дүрст хээ угалз, луу, гарьд, буга, ирвэс, тогоруу, яст мэлхий, загас, арслан, барс, галуу, тоть мэт амьтны дүрст хээ угалз, нар, сар, гал, од, чандмань, өлзий, хас, алх, хамар, эвэр, үүл, хаан хатан сүйх, ланз, тууз, пүүс зэрэг өлзий бэлгэт хээ угалзаас гадна үсэг дүрс, асар тагт, хүүхэд багачуул, жүжиг тоглолт, түүхэн үлгэрийн зураг дүрстэй хээ угалзыг өргөнөөр хэрэглэж байв. Чимэглэлийн дүрс, өнгө будаг, их багаар дэс, албан тушаал ялгаж, гол таних тэмдэг болгох дэг ёсыг хуульчлан тогтоосон (Наранхүү, Ян Жин. 2006.х.70) байжээ.

Зураг 2

Галт шувуу, луун хээт торго. Юань улс



Тухайлбал, “тэргүүн дэсийн түшмэд ганц хүйт их цэцэг, дэд дэсийн түшмэд ганц хүйт бага цэцэг, гутгаар дэсийн түшмэд салаа навчгүй тархмал цэцэг, дөрөв, тав, зургаа, долдугаар дэсийн түшмэд элдэв жижиг цэцэгс хатгаж урласан дээл гэхчлэн зэрэг буурах тусам хээ чимэглэл нь жижгэрсээр, хамгийн доод дэсийн

найм, есдүгээр дэсийн түшмэд ямар ч хээ угалзгүй цулгүй дээл өмсөнө. Түшмэд бүгд улаан сураар үйлдэж, хаш чулуу, эвэр чимэгтэй толин бүсээр гоёх ба тэргүүн зэрэгтэн шулуун буюу хээтэй хаш тоногтой, дэд дэсийн түшмэд хээтэй хирсний эвэртэй, гурав ба дөрөвдүгээр дэсийн түшмэд шар алтаар луун нүд хийсэн, түүнээс доод дэсийн түшмэд хар хирсийн эвэр чимэгтэй бүс бүсэлнэ” (Нямбуу. Х. 2002.х.40) гэхчлэн чимэглэл сэлт, хээ угалзын зүйлээр зэрэг, дэс, албан тушаалыг сайтар ялган, нарийн дүрэмлэн тогтоосон байна.

2. Шаазангийн хээ угалз

Их Юань гүрний үе бол шаазан урлалын бүтээгдэхүүний хөгжлийн шинэ нэгэн цаг үе юм. Үүнд онцлон дурдууштай нь цэнхэр цагаан шаазан ба гялалзсан улаан шаазангийн будалт юм. Юань улсын шаазан үйлдвэрлэлийн төв нь Жин Дэ балгас (одоогийн Жиян Си мужийн Жин Дэ хот) байсан бөгөөд шаазан бүтээгдэхүүний арга технологи, төрөл зүйл, хийц маяг маш түргэн цэцэглэн хөгжсөн байдаг. Энэ газрын шаазан урлал одоо ч тухайн үеийн уламжлалаа хадгалсан хэвээр бөгөөд гадаад дотоодод нэр алдар нь дуурсаж байдаг юм. тухайн үед Жин Дэ балгасанд эл төрлийн ваар шаазан урлаачид хэдэн түмээр цуглаж байсан бөгөөд “300 гаруй ваар шаазан шатаах үйлдвэр байжээ” (Ганболд Ж нар. 2006. хууд 77)Цэнхэр цагаан шаазан гэдэг нь цагаан өнгөөр дэвсгэр болгож, хөх өнгөөр хээ угалз тавьж чимэглэсэн шаазан юм. 1200-1300 градусын халуун зууханд шатаадаг. Цэнхэр болон цагаан өнгийн ялгамж тод бөгөөд цэвэр, хээ дүрслэл нь уран тансаг, хэзээ ч арилж бүдгэрдэггүй. Монголчуудын эртнээс нааш эрхэмлэн дээдэлсээр ирсэн хөх, цагаан хоёр өнгийн хослолыг баруун Арабын шаазан хийх ур мэргэжилтэй хослуулсан нь аргагүй төгс зохицолдолгоог олж чадсан байна.

Зураг 3

Эрдэнийн чулуу шигтгэсэн хөх хээт ваар. Юань улс.



Шаазангийн хэв ба шаазан эдлэл дээр шууд паалангаар зураад, өнгөлөг ширээр гадарлаж, халуун зууханд удаан шатаадаг учир өнгө ялгарал хурц тод, хээ зураглал нь цэвэр гардаг онцлогтой. Уламжлалт шаазан үйлдвэрлэлд сийлэх, шуух аргаар хээлж чимэглэдэг байснаа зурах аргаар чимэглэх болсон шинэ нэгэн дэвшил байлаа. Шаазангийн чимэглэлд өрнөдийн хэв маяг бүхий сэдэв агуулга, хэлбэр дүрсийг нэвтрүүлсэн нь Монголчуудын тухайн үеийн бас нэгэн урлагийн шинэ ололт болох юм. Тухайлбал, уламжлалт мандарваа, удвал, лянхуа, тоор, гүйлс болон луу, гарьд, тогоруу, буга, загас буюу хас, алх, өлзий, чандмань гэх мэт хээ угалзаас гадна эртний домог үлгэр, жүжиг, түүх, ардын үлгэр, цаашлаад барууны ороомол хээ, үргэлжилсэн сувд, анар, Араб үсэг, геометрийн дүрст хээ ч элбэг тохиолддог. Ороомол өвс, үргэлжилсэн сувд, Араб геометрийн дүрс хээгээр шаазан эдлэлийн ихэвчлэн ирмэг амсар, суурь, хөвөөг чимсэн байдаг бол луу, гарьд, загас, мандарваа, домгийн амьтан, үлгэрийн үйл явдал, олон зүйлийн ургамлын цоморлиг зэрэгт сэдэвт зохиомжуудыг шаазан эдлэлийн их биед дүрсэлж, өрнө дорны хэв маягийг хослуулсан нь тухайн үеийн шаазан урлалын бас нэгэн онцлог болсон байна. Хээ чимэглэлийн дотроос луу, гарьд, мандарваа цэцэг гэх мэт зураг дүрс нь хамгийн түгээмэл хэрэглэгдэж байсан бөгөөд түүнээс хойших цаг үеүдэд ч монголчуудын дуртай хээ угалз байсаар иржээ. Юань гүрэнд могойн бие, тэмээн толгой, бугын эвэр, загасны хайрс, бүргэдийн савар зэрэг олон төрлийн араатны амьтны тал дүрсээр нийлүүлж нэгтгээд луу хэмээх зөн билгийн амьтны дүрийг, гургуулын толгой, тогосны хүзүү, уран хажингийн бие, бүргэдийн далавч, тогорууны хөл, тогосны өд зэрэг мөн л олон зүйлийн жигүүртэн шувуудын нийлмэл дүр бүхий гарьд шувуу зэрэг бодит хийсвэр хоёрыг хослуулсан зөн билгийн дүрүүдийг зураглан бүтээж, түүнээ элдэв зүйлийн чимэглэлд өргөн хэрэглэсэн байдаг. Түүнчлэн мандарваа, лянхуа, алх, чийрс, хаан хатан сүйх мэтийн геометрийн дүрс хээ угалз ч улмаар дүрэмжсэн байдаг. “Юаний үеийн шаазангийн чимэглэл дэх иймэрхүү дүрэмжсэн бодитой хэлбэр маягийн зурж бүтээх зохиомжийн арга барил нь амьдлаг мөртөө өвөрмөц онц чимэглэлийн арга болсон байна.” (Жан Дао И.1995. хууд 189) Чимэглэлийн хээ угалзыг агуулга дүрсээр нь нарийн нягт, эмх замбараатайгаар шаазан эдлэлд дээрээс доош, дөрвөөс дээш найм, есөн мөрөөр эгнүүлэн жагсаасан зохиомжийн хэлбэр нь Юань гүрний шаазан чимэглэлийн бас нэгэн онцлог юм.

Зураг 4. Эрдэнийн чулуу шигтгэсэн Хөх хээт ваар. Юань улс. БНХАУ. Нийслэлийн музей



Гялалзсан улаан паалант шаазан нь хүчилтөрөгч зэсээр будаг болгон чимэглэн зурагласан хээ угалзын зураглал хийцээр цагаан дэвсгэрт өнгө гэх мэтээрээ бусад төрлийн шаазангаас онцлогтой. Амьтан, ургамал, домог үлгэр, геометрийн дүрс гэх мэт хээ угалзаар чимэглэсэн ба цагаан шаазан, хөх шаазан, цагаан дэвсгэрт хар шаазан гэх мэт чимэглэлийн хээ дүрсийг нь монголчилсон шаазан чимэглэлийн бүтээгдэхүүнүүд Монголчуудын ардын амьдрал дунд уламжлагдан хэрэглэгдэж байжээ.

3. Алт, мөнгөн эдлэлийн хээ угалз

Юань гүрний үед Монголчуудын дунд алт мөнгөний хэрэглээ хэзээ хэзээнйхээс илүү өргөн дэлгэрэв. Алт, мөнгөөр урласан эдлэл хэрэглэлийн хэлбэр маяг, төрөл зүйл олширч, ур хийц нь улам



бүр нарийлаг гоёмсог болсон байна. Төр засгаас алт, мөнгөний дархны газрыг тусгайлан дэмжин ажиллуулж, хаад ноёд, язгууртнуудын өдөр тутмын хэрэглээний эд, эдлэлийг үйлдвэрлэдэг байжээ. Загварчлах, сийлэх, сэжимдэн ороох, алаглуулах, алтаар угаах гэх мэтээр хийц мэргэжил тун их хөгжсөн байдаг. Тухайн цагийн нийгмийн хэрэгцээ нөхцөлөөс шалтгаалан өдөр тутмын эдлэл хэрэгслээс гадна эл төрлийн засал чимэглэлд ч алт, мөнгийг тун өргөн хэрэглэж байжээ. “Алт мөнгө, зэс төмөр, цайр, хөнгөн цагаан, мөнгөн усны олдвор ихэсч, улсын

хэмжээнд том алтны уурхай 40 байжээ” (Ганболд Ж нар. 2006. х.73) Алт мөнгөн эдлэлийн чимэглэлд хээ угалз нь удвал, тоор, лянхуа, мандарваа зэрэг цэцэг өвс ургамлын дүрст хээ угалзыг түгээмэл хэрэглэхээс гадна, луу, гарьд, яст мэлхий, буга зэрэг амьтны дүрст хээ угалз үлэмж харагддаг. Жишээлбэл, 1955 онд Ан Хуй мужийн Хэ Фэй өмнө хаалгаас олдсон Юань гүрний үеийн 102 төрөл алтан хундага, хайрцаг, таваг, шанага, савх зэрэг эдлэл олноор олдсон (Чү Шү Шэнь. 1999. хууд 309). Тэдгээрээс харахад хийсэн ур мэргэжил нарийлаг гойд, дүрс хэлбэр онцгой, хээ чимэглэл баялаг, чимэглэлийн хэр зэрэг тун өндөр байжээ. Үүнээс зургаан талт алтан сав нь таглаа, давхар хэцэт их бие, суурь гэсэн гурван хэсгээс бүрдэх бөгөөд арван хэлтэст лянхуа цэцгийн дүрсээр тойруулан бүтээж, хайрцгийн бүхий л биед ороомол хээ угалзыг жигдхэн сийлж, таглаанд нь хос гарьд жигүүр дэлгэн дүүлэн нисч буй дүрслэлтэй, туузан хээг товойлгон сийлжээ. Түүний завсарт нь одон цэгийн сийлбэрийн аргаар үргэлжлүүлэн мандарваа, удвал цэцгээр чимэглэсэн ба суурийн хэсэгт ороомол өвсөн хээгээр тойруулан холбож эмжсэн байна. Хээ угалзыг сийлсэн ур арга нь хувиралт ихтэй ба гол дэд ялгаран, уран тансаг харагддаг.

Зураг 5. Алтан сав. Юань улс. Анхуй Муж

Юань гүрний үед өдөр тутмын эдлэл хэрэгслээ алт мөнгөөр урлаж хийдэг байж, түүний дээр нь оюу, шүр шигтгэн чимэглэсэн эд хэрэглээ баялаг мөртөө элдэв зүйлийн дүрст хээ угалзаар засан чимэглэх ба анар, үргэлжилсэн сувд хээ, Араб үсгийн дүрст хээ угалз гэх мэт, харийн улс орны соёл урлагийн үнэр амт бүхий хээ чимэглэлүүд элбэг харагддаг.

4. Шир будагт эдлэлийн хээ угалз



Юань гүрний үед уламжлалт ур хийцтэй шир будагт эдлэл хэрэгсэл язгууртнуудын дунд төдийгүй эгэл ардын дунд уламжлагдан хөгжсөөр иржээ. Онцгойлон Жиа Шин, Ханжөү, Вэнжөү,

Фү Жиян гэх мэт газар оронд их хэмжээний арьс шир будагт эдлэл үйлдвэрлэдэг байжээ. (Хуй Гү. 2008. хууд 267) Тухайн үед хамаарах ширт эдлэлийн дурсгалын олонх нь өдөр тутмын хэрэгсэл, тавилга, барилгын чимэглэл, тэрэг, морины эдлэлийн заслууд байна. Цэцгийн дэлбээт хээг сийлж чимэглэсэн ширт хайрцаг нь шар өнгийн дэвсгэр дээр улаан өнгийн ширийг олонтоо талхидан улайлгаад, тавгийн гол хэсэгт нь ганган дэлгэрсэн мандарваа цэцгийн хээ сийлэн, салаа намиаг нь чөлөөтэй эвхрэлдүүлэн ороож, тойрог туузан хээнд зохицуулан зохиомжилж, амьдралын мандаж бадрахыг бэлгэдсэн шинжтэй тансаг эрчимлэг харагдана.

Зураг 6. Ширт хайрцаг. Юань улс

Алт мөнгөн шигтгээтэй ширдэж будсан эдлэл нь уул, ус, хүн амьтан, асар тагт, цэцэг навч, шувуун хээгээр бялхаж, Монголчуудын таашаал сонирхолтой нийцэн зохилдож, Монголчуудын аж амьдралын дунд өргөнөөр тархсан байжээ.

Юань гүрний үеийн эдгээр гар урлалын бүтээл нь ихэс дээдсээс, эгэл ардын өдөр тутмын хэрэглээнд хүртэл өргөн тархсан нь тухайн үеийн монголчуудын дунд гар урлалын үйлдвэрлэл тун өндөрт хөгжиж, нийгмийн аливаа хүрээ давхаргад жигд тархсаныг илтгэж байна. Хээ угалзын дүрс хэлбэр, өнгө будаг, ур хийц нь тухайн үеийн Монголчуудын даяаршсан нийгмийн үзэл санаа, байгалийн эд бодисын баялаг бялхам, уран сэтгэхүй, үндэстний авьяас чадвар энэрлийн үзэл санаа ба амьдралын тансаг баяныг харуулна. Энэ нь тухайн үеийн соёл урлаг, цаашлан дэлхийн гар урлалын дэлгэрэл хөгжилт ба хээ угалзын зураг дүрсийн төрөл зүйл, утга агуулга, хэрэглээнд тун их ач холбогдол үзүүлсэн юм.

Дүгнэлт

Тал нутгийн нүүдэлчин угсаатай Монгол түмний байгуулан цэцэглүүлсэн Их Юань гүрэн нь тухайн цаг үеийн дэлхийг дамнасан их гүрэн байсны хувьд хил дамнасан худалдаа наймаагаар соёл урлагийн хөгжлийг ахиулаад зогсохгүй мөн дотоод гар урлалын үйлдвэрлэлийг ихээр дэмжин хөгжүүлсэн нь өөрийн онцлог бүхий гар урлагийн хэв намыг бүрдүүлжээ.

Энэхүү нөхцөл байдал нь Монголчуудын уламжлалт үзэл ухамсар, гоо сайхны таашаал өдөр тутмын амьдралд хүртэл шинэ утга агуулга, шинэ хэрэглээ, шинэ хэвшлийг авчирсан байна.

Түүнийг тухайн үеийн бөс нэхмэлийн хээ угалз, шаазангийн хээ угалз, алт, мөнгөн эдлэлийн хээ угалз, шир будагт эдлэлийн хээ угалзын онцлогоос харж болохоос гадна монгол үндэсний

хээ угалз улам баяжигдан өвөрмөгц тогтолцоог буй болгосон байна.

Монголчуудын уламжлалт нүүдэлчин соёл, Хятадын суурин соёл, Баруун болон Дундад Ази, Европын соёлын харилцан нэвтрэлт, нөлөөлөл нь Юань гүрний хөгжил дэвшлийн гол зангилаа болж, соёл урлагийн энэхүү солбицол дээр хээ угалзын тогтолцоот уламжлалт гар урлал өвөрмөгц өнгө төрхөөр улам хөгжин цэцэглэжээ.

Ашигласан материал

- Балжинням.,Эрдэнэхүү., Жан Жи Ся. (2005).
Мянган оны тууж – Ганц хүн. Бээжин:
Үндэстний хэвлэлийн хороо.
- Ганболд.Ж.,Мөнхцэцэг.Т.,Наран. Д.,Пунсаг.А.
(2006). Монголын их Юань улс. МУШУА.-
ийн Түүхийн хүрээлэн. Улаанбаатар: Ad-
mon хэвлэлийн газар.
- Юань улсын судар. 93-р боть. Амуу хүнс, эд
барааны тэмдэглэл
- Хуй Гү. (2008). БНХАУ-ын хээ угалзын түүх.
Бээжин: Ардын уран зургийн хэвлэлийн
хороо.
- Монголчуудын засал чимэг. (2006) Ред:
Наранхүү, Ян Жин. Хөх: Өвөр Монголын
ардын хэвлэлийн хороо.
- Амарбат. (2008). Монгол үндэстний гар урлалын
түүх. Улаан хад: Өвөр Монголын шинжлэх
ухаан техникийн хэвлэлийн хороо.
- Нямбуу. Х. (2002). Монгол хувцасны түүх.
Улаанбаатар.
- Жан Дао И. (1995). Хятадын хээ угалз. Тайвань:
Хуан Фу хэвлэлийн хороо.
- Чү Шү Шэнь. Юань улсын товч түүх. -Фу Жиян.:
Соёлын хэвлэлийн хороо. -1999. –Х. 309